





**Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн ТУЗ-ийн даргаар Очирсүрэн овогтой Болдбаатар (РД:)-ыг сонгосугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн дарга сонгогдсоныг Компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр), Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ийн гишүүд

 _____ /О.БОЛДБААТАР/  _____ /КАЦУХИКО МАДОНО/  _____ /П.ОТГОНБАЯР/  _____ /С.ЭНХ-АМГАЛАН/  _____ /Ц.УУГАНБАЯР/	 ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ 5039754 Ж.1118267206	 _____ /Ц.ТҮМЭНЦОГТ/  _____ /Х.БАТСҮРЭН/  _____ /С.НЭРГҮЙ/  _____ /Б.ХОС-ЭРДЭНЭ/
--	--	---

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 26/20

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн санал, Компанийн ТУЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Хүчитбаатар овогтой Хулан (РД:)-ыг томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилогдсоныг Компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр), Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Хулан) нарт үүрэг болгосугай.



**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын
бүрэлдэхүүнийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

- 1.1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо:

Хорооны дарга: ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Болдбаатар;
Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Х.Батсүрэн;
ТУЗ-ийн Ердийн гишүүн Б.Хос-Эрдэнэ;
ТУЗ-ийн Ердийн гишүүн Ц.Ууганбаяр;
ТУЗ-ийн Ердийн гишүүн Кацухико Мадоно;
ТУЗ-ийн Ердийн гишүүн С.Энх-Амгалан.

- 1.2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо:

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй;
Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ц.Түмэнцогт;
ТУЗ-ийн Ердийн гишүүн П.Отгонбаяр.

- 1.3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хороо:

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Х.Батсүрэн;
Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ц.Түмэнцогт;
ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Болдбаатар.

- 1.4. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ц.Түмэнцогт;
Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй;
ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Болдбаатар.

2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал

(Ц.Ууганбаяр), Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Хулан) нарт үүрэг болгосугай.



**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны ээлжит хурлын хуваарь батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2026 оны ээлжит хурлын хуваарийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг тогтоосон хугацаанд хуралдуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д, түүнд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.



**Төлөөлөн удирдах зөвлөлийн
ажлын болон сургалтын төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн үүрэг даалгаврыг биелүүлэх ажлын хүрээнд Компанийн ТУЗ-ийн 2026 оны Ажлын төлөвлөгөөг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр, ТУЗ-ийн 2026 оны Сургалтын төлөвлөгөөг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор тус тус баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтуудаар батлагдсан төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлж, Компанийн ТУЗ-ийн төлөвлөгөөт ажил болон холбогдох сургалтыг зохион байгуулах, хамрагдсан сургалтын талаар Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 26/24

Улаанбаатар хот

Мөнгөн хөрөнгийн удирдлагын журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 болон 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь мөнгөн хөрөнгийг зохистой, үр ашигтай удирдаж, мөнгөн хөрөнгийн ашигт байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр өдрийн 26/08 тоот тогтоолоор батлагдсан “Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам”-д өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасны дагуу өөрчлөлт орж буй “Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр батлагдсан Компанийн “Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү Журмын өөрчлөлттэй холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 26/25

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн гадаад валютын эх үүсвэрийг үр ашигтай удирдах, ханшийн эрсдэлээс хамгаалан хеджинг хийх зорилгын хүрээнд олон улсад энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг FCC Securities B.V.-тэй хамтран ажиллах, ийнхүү хамтран ажиллахад шаардлагатай гэрээ, хэлцэлүүдийг байгуулах хүсэлтэй байгааг дурдсугай.
2. Хеджинг хийх болон гадаад валютын эх үүсвэрийг үр ашигтай удирдахтай холбогдуулан дараах гэрээ, баримт бичгүүд (цаашид “**Хеджинг баримт бичиг**”), түүнчлэн энд дурдагдаагүй боловч шаардлагатай бусад бүхий л баримт бичгүүдийг зохих ёсоор үйлдэж, баталгаажуулахыг Компанид зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 2.1. Мастер гэрээ 2002 (2002 Master Agreement);
 - 2.2. Мастер гэрээ 2002-н Хавсралт (Schedule to the Master Agreement 2002)
 - 2.3. Энд дурдсан баримт бичгүүдэд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт, тэдгээртэй хамааралтайгаар үйлдсэн болон бусад дагалдах баримт бичгүүд.
3. Хеджинг баримт бичгүүдийн нөхцөлийг тохиролцох, эдгээрийн нөхцөлийг эцэслэх, гарын үсэг зурах, баталгаажуулах, мөн гүйцэтгэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Хеджинг баримт бичгүүд, түүнтэй холбоотой авч хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 26/26

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20, 9.6.23 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн АХ-26/05 тоот дүгнэлт болон 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь LendMN аппликейшн, түүний үндсэн болон дагалдах системүүдийн бүхий л хөгжүүлэлт, засвар, үйлчилгээг хийлгэхээр “АНД Сольюшн” Пти.Лтд-тэй 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдөр 2021/38 тоот “Программ хангамжийн үйлчилгээний гэрээ” байгуулан ажиллаж буйг дурдсугай.
2. “АНД Сольюшн” Пти.Лтд-ийн зүгээс 2021/38 тоот “Программ хангамжийн үйлчилгээний гэрээ”-ний хүрээнд үзүүлж буй технологийн үйлчилгээг цаашид Монгол Улсад чиглэн технологийн үйлчилгээ үзүүлж буй “АНД Системс Тех” ХХК-аар дамжуулан үзүүлэхээр төлөвлөсөн болохыг тэмдэглэсүгэй.
3. Энэхүү шилжилттэй нийцүүлэн, Компанийн зүгээс “АНД Системс Тех” ХХК-тай өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, шинэчлэлт сайжруулалтыг тогтмол хийх, ирээдүйн төлөвлөж буй бизнесийн тэлэлтийг хийхтэй холбогдуулан үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх чиглэлээр хэлцэл хийж, “Программ хангамжийн үйлчилгээний гэрээ”-ний үндсэн нөхцөлийг шинэчилсэн болохыг дурдсугай.
4. “АНД Системс Тех” ХХК-тай “Программ хангамжийн үйлчилгээний гэрээ” байгуулах нь Компанийн технологийн үйлчилгээний хүрээг илүү өргөжүүлэх, сайжруулах, түүнчлэн уян хатан болгох боломжтой тул “АНД Системс Тех” ХХК-тай “Программ хангамжийн үйлчилгээний гэрээ”-г шинэчлэн байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
5. “АНД Системс Тех” ХХК-тай байгуулах “Программ хангамжийн үйлчилгээний гэрээ”-ний үндсэн нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, тус батлагдсан нөхцөлийн дагуу “АНД Системс Тех” ХХК-тай бусад нөхцөлийг Компанийн эрх ашигт нийцүүлэн тохирч, холбогдох гэрээ, хэлцлийг байгуулах, түүнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
6. Цаашид энэхүү Тогтоолын дагуу байгуулагдсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлцэл хийх, бусад холбогдох гэрээ, хэлцэл байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
7. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, түүний үр дүн болон энэхүү Тогтоолын дагуу байгуулагдсан гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ талаар тухай бүр

Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал
(Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

ТУЗ-ийн гишүүд:

ЛЭНДМН ББСБ ХК

Ц.ТҮМЭНЦОГТ

lendmn

УЛААНБААТАР ХОТ

54 1118267206

С.НЭРГҮЙ

Х.БАТСҮРЭН


С.ЭНХ-АМГАЛАН

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20, 9.6.23 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн АХ-26/06 тоот дүгнэлт болон 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь өөрийн бизнесийн үйл ажиллагаа нэмэлтээр шаардлагатай нарийн мэргэжлийн үйл ажиллагаа буюу олон улсын хөрөнгө оруулалт, санхүүжилт, бизнес хөгжил, хууль зэрэг чиглэлээр туслалцаа, зөвлөх үйлчилгээ авах зорилгоор өөрийн толгой компани болох “АНД Системс” ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр AS-20/27, 2020/07 тоот “Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ”-г байгуулан ажиллаж буйг дурдсугай.
2. Компани нь “АНД Системс” ХХК-тай байгуулсан AS-20/27, 2020/07 тоот “Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулж, толгой компаниас авч буй Менежментийн зөвлөх үйлчилгээний ажлын цар хүрээг нарийвчлан тодорхойлох хүсэлт ирүүлсэнтэй танилцаад уг нэмэлт, өөрчлөлтөөр уг гэрээний үнийн дүн өөрчлөгдөхгүй, гэрээний дагуу авч буй үйлчилгээний уялдаа, ангилал, цагийн бүртгэл илүү нарийвчлалтай хийгдэхийг харгалзан үзэж, Компанид AS-20/27, 2020/07 тоот “Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан зөвлөх үйлчилгээний ажлын цар хүрээг нарийвчлан тогтоосон нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, уг нөхцөлийн дагуу “Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээний нэмэлт, өөрчлөлтийн гэрээ №3”-г толгой компанитай байгуулах, түүнд гарын үсэг зурж, баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, түүний үр дүн болон энэхүү Тогтоолын дагуу байгуулагдсан гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ талаар тухай бүр Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

ТУЗ-ийн гишүүд:

 Ц.ТҮМЭНЦОГТ	 Х.БАТСҮРЭН
 С.НЭРГҮЙ	 С.ЭНХ-АМГАЛАН



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ± 1118267206

**2026 оны санхүүгийн тайланд
хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн АХ-26/07 тоот дүгнэлт болон 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2026 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, тэдгээртэй гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.



**“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн 2026 оны санхүүгийн тайланд
хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “**Компани**”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн дүрмийн 6.1, 8.4.15 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “**ТУЗ**”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн АХ-26/08 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн охин компани болох “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн 2026 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Шонхор үнэлгээ аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, тэдгээртэй гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Ж.Сосор)-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Ж.Сосор)-д, толгой компанийн хувьд хяналт тавьж ажиллахыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д тус тус даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

№ 26/30

Улаанбаатар хот

“Супер Ап Хэтэвч” ХХК-ийн 2026 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, “Супер Ап Хэтэвч” ХХК-ийн дүрмийн 12.43 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн АХ-26/09 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн охин компани болох “Супер Ап Хэтэвч” ХХК-ийн 2026 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Дата Профешнл Эдвайзори” ХХК-ийг сонгосугай.
2. “Дата Профешнл Эдвайзори” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, тэдгээртэй гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг “Супер Ап Хэтэвч” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, толгой компанийн хувьд хяналт тавьж ажиллахыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д тус тус даалгасугай.

